

БАТЛАВ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



МТ ПЕТРОЛИУМ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ШАТАХУУН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № *15/23*

2023 оны 06-р сарын 20 өдөр

2023 он 06 сарын 23

2023/27

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө нөгөө талаас МТ Петролиум ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал А.Туул /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа Ажил Үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Шатахуун” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох гэрээний хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, барааны жагсаалт, техникийн үзүүлэлт, стандартын дагуу шаардлага хангасан барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн шатахуун түгээгүүрт нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь гурван нэр төрлийн барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс буюу 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний үнийн дүнд гааль онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн түгээгүүрт хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2 Гэрээний хугацаанд шатахууны үнийг сар бүрийн 5-ны өдрийн дотор харилцан тохиролцоно.
- 3.3 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

Захиалгач

1/5

Нийлүүлэгч

3.4 Барааг хуваарийн дагуу хүлээн авсны дараа сар бүрийн 5-ны дотор нэхэмжлэлийг үндэслэн нийлүүлэгчийн Хаан банкны 5028129620 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

- 4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -с хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааг хүлээн авсны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, хэрэв төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Бараа нь захиалагчийн мөрдөж байгаа стандарт, шаардлагад нийцсэн, худалдан авагчийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.
- 4.4 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс ажиллаж барааны тоо хэмжээ, монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох стандарт чанарын үзүүлэлт, техникийн шаардлага хангасныг баталгаажуулсан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг үндэслэн барааг хүлээн авна.
- 4.5 Барааг ашиглах явцад чанарын доголдол, шаардлага хангаагүй тохиолдолд ирүүлсэн дээжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, хор хохирол учирсан тохиолдолд тухайн өдрөөс хойш 3 хоногийн дотор хохирлыг төлнө
- 4.6 Нийлүүлэгч нь захиалагч талын /Улсын онцгой объект/-т тул захиалсан барааг /өвөл, зуны түлш/ гэж заасан бол **яаралтай горимоор** захиалсан тоо хэмжээгээр хугацаанд нь зориулалтын түлшийг саадгүй нийлүүлэх үүрэгтэй. Шатахууныг тухай бүр бүрэн гүйцэт шахаж өгнө.
- 4.7 Захиалагч тал Дизель түлш жижиглэнгээр болон автобинзен /Аи-92/-ийг нийлүүлэгчийн хамгийн ойр байрлах шатахуун түгээх станцаас очиж авна.
- 4.8 Зах зээл дээр шатахууны хомсдол үүссэн эсэхээс үл хамааран захиалагч талд шатахууныг тэргүүн ээлжинд захиалсан хэмжээгээр тасалдуулахгүй нийлүүлнэ.
- 4.9 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн үндсэн хөрөнгийн нягтлан бодогч Н. Нэргүй хариуцан ажиллана. Утас-94020411.
- 4.10 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг МТ Петролиум ХХК-ийн борлуулалтын ахлах менежер А.Мөнхжаргал хариуцан ажиллана. Утас-93113737.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Барааг хүргэхдээ тэсэрч, дэлбэрэхээс хамгаалагдсан, шатахуунаа түгээгүүрт шахдаг зориулалтын хоолойтой /10тн, 20тн, 30тн/-ын багтаамж сайтай автомашинаар тээвэрлэнэ.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын шинж, стандарт чанараа алдахгүй байх ёстой.

- 5.4 Нийлүүлэх бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй зүйл илэрвэл нийлүүлэгч дутагдлыг арилгана. Шатахууныг буцаах шаардлага гарвал сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь захиалагч барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **7 хоногийн** чанарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан зөрчил, дутагдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.
- 5.6 Барааг дараах бичиг баримт дагалдана.
- Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг
 - Үйлдвэрлэгчийн сертификат
 - Барааны марк, үнэ, хэмжээ, нэхэмжлэх, зарлагын баримт

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн шатахуун түгээгүүрт бараа хүлээн авах ажилтанд хүлээлгэн өгнө.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаях зэрэг нөхцөлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцөлүүд хэсэгчлэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 /тав/ хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.
- 7.3 Давагдашгүй хүчин зүйл тохиосныг Худалдаа аж үйлдвэрийн танхимын албан бичиг /тодорхойлолт/ нотолно.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь захиалагч талын шатахуун авахаар захиалсан хугацааг 1 /нэг/ хоногоор хэтрүүлсэн, гэрээний үүргээ давтан биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 1 /нэг/ хоногийн дотор зохих хариуг бичгээр өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч тал дангаар гэрээг цуцална.
- 8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ давтан буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбоотой мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 1 /нэг/ хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй. Гэрээ дүгнэсэн, сунгасан, нэмэлт өөчлөлт оруулсан баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн оруулгыг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 9.8 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мөрдөж ажиллах бөгөөд үүрэг зөрчигдсөн тохиолдолд санаачлагч талын гомдлыг үндэслэн харилцан тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрхэмлэж хамтын шийдвэр гаргаж байна. Хэрэв тохиролцоогүйд хүрвэл шүүхэд асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

 Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Г.БАТТУЛГА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Г.САРУУЛ


ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН

 М.МОЛОМЖАВ


Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МТ ПЕТРОЛИУМ ХХК-ИЙН
ХУДАЛДАА, БОРЛУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

 Д.АЮУРБУНЬ

БОРЛУУЛАЛТЫН АХЛАХ МЕНЕЖЕР

 А.МӨНХЖАРГАЛ

Хаяг: СБД 6-р хороо НҮ-ний гудамж МТ байр
Утасны дугаар: 93001010, 83001010
РД: 5043913

Захиалгач



5/5

Нийлүүлэгч